ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗРЫН 2022 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

**АУДИТЫН КОД: ДАА-2023/101/НА-СТА-ТШЗ**

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.


**Дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр**

Утас: 70373089 Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn

**Аудитын менежер У.Батсүрэн**

Утас: 70373089 Цахим хаяг: batsurenu@audit.gov.mn

**Ахлах аудитор С.Батцэцэг**

Утас: 70373089 Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn

**Ахлах аудитор Х.Сувдмаа**

Утас: 70373089 Цахим хаяг: suvdmaakh@audit.gov.mn


Дархан-Уул аймаг

2023 он

АГУУЛГА


**1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ** ........ 3

**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ** ........ 5

**4. АУДИТЫН ТАЙЛАН** ........ 18

4.1 Ерөнхий зүйл ........ 18

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт ........ 18

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ........ 18

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ........ 18

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ........ 19

4.5.1 Завсрын аудитын талаар ........ 19

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ........ 19

**5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ** ........ 20

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| МХЕГ | Мэргэжлийн хяналтын ерөнхий газар |
| ҮОМШӨ | Үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчин |
| ЗГНХ | Засгийн  газрын нөөц хөрөнгө |
| ЗДНХ | Засаг даргын нөөц хөрөнгө |
| ХХК | Хязгаарлагдмал хувьцаат компани |

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Бурхантын гудамж-1,14 дүгээр баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45059,
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2023.02.24 № 51

танай ______-ны №______ -т

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ЗДТГ-ЫН ДАРГА
БӨГӨӨД МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗРЫГ
ТАТАН БУУЛГАХ ДЭД КОМИССЫН ДАРГА
О.ХҮРЭЛЧУЛУУН ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Тус газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

МХЕГ-ын даргын 2022 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн А/21 дүгээр тушаалаар үнэ төлбөргүйгээр 21,925.3 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг хүлээн авч, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны 03 сарын 17-ны өдрийн 90 дүгээр тогтоолын дагуу 5,836.8 мянган төгрөгийн балансын үнэтэй хөрөнгийг аймгийн Гаалийн газарт шилжүүлсэн байна.

**Аудитын гол асуудал**

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 417 дугаар тогтоолоор Засгийн газрын тохируулагч агентлаг Мэргэжлийн хяналтын ерөнхий газрыг 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон татан буулгасан байна.

**Бусад асуудлын хэсэг**

Төсвийн шууд захирагч бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Дархан-Уул аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 11 зорилтын хүрээнд 32 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжилтийг 87.5 хувиар дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

009020064

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ш.МӨНХБАЯР

9022899
4517143826

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эхний үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **105,252,487.33** | **59,252,182.50** |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **105,252,487.33** | **59,252,182.50** |
| **351** | **Түүхий эд материал** | **10,828,031.07** | **832,940.00** |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 3,080,959.64 | 317,940.00 |
| 35130 | Эм боох материал | 4,900,000.00 | 515,000.00 |
| 35300 | Бэлэн бүтээгдэхүүн | 2,847,071.43 | - |
| **354** | **Хангамжийн материал** | **94,424,456.26** | **58,419,242.50** |
| 35410 | Бичиг хэргийн материал | 11,255,240.92 | 785,000.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 5,164,156.00 | 1,869,366.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 3,195,000.00 | - |
| 35460 | Хүнсний материал | 271,000.00 | - |
| 35470 | Бусад хангамжийн материал | 74,539,059.34 | 55,764,876.50 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **198,686,135.97** | **189,458,658.05** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **198,686,135.97** | **189,458,658.05** |
| **392** | **Биет хөрөнгө** | **86,186,135.97** | **76,958,658.05** |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 297,744,594.00 | 297,744,594.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (270,585,231.99) | (276,377,183.21) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 190,235,785.68 | 213,754,319.84 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (160,281,612.77) | (175,355,409.50) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 33,814,846.55 | 33,338,310.55 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (27,806,493.58) | (29,234,815.17) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 211,411,897.00 | 211,411,897.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (188,347,648.92) | (198,323,055.46) |
| **393** | **Биет бус хөрөнгө** | **112,500,000.00** | **112,500,000.00** |
| 39301 | Программ хангамж | 713,000.00 | 713,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (713,000.00) | (713,000.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 112,500,000.00 | 112,500,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **303,938,623.30** | **248,710,840.55** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **303,938,623.30** | **248,710,840.55** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **303,938,623.30** | **248,710,840.55** |
| **511** | **Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан** | 352,787,782.82 | 352,787,782.82 |
| 51101 | Өмч: - төрийн | 352,787,782.82 | 352,787,782.82 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | **(48,849,159.52)** | **(104,076,942.27)** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 23,434,453.95 | (49,439,842.66) |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | (72,874,296.61) | (55,227,782.75) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 590,683.14 | 590,683.14 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **303,938,623.30** | **248,710,840.55** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **925,883,249.50** | **797,589,416.64** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **97,432,849.50** | **52,897,716.64** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **97,432,849.50** | **52,897,716.64** |
| 120004 | Төсөвт байгууллагын өөрийн орлого | 97,432,849.50 | 52,897,716.64 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 56,710,500.00 | 28,784,650.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 40,722,349.50 | 24,113,066.64 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **828,450,400.00** | **744,691,700.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **827,698,400.00** | **724,691,700.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 827,698,400.00 | 724,691,700.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **752,000.00** | **20,000,000.00** |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 20,000,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 752,000.00 | - |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **998,757,546.11** | **852,269,234.29** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **998,757,546.11** | **852,269,234.29** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **880,937,323.97** | **799,104,476.61** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **536,066,722.95** | **506,962,115.22** |
| 210101 | Үндсэн цалин | 383,329,957.85 | 394,984,850.87 |
| 210102 | Нэмэгдэл | 140,523,765.10 | 84,844,032.17 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 12,213,000.00 | 11,438,610.05 |
| 210104 | Урамшуулал | | 15,694,622.13 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **69,686,180.91** | **63,561,791.10** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 48,584,426.92 | 43,987,720.25 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,413,016.39 | 5,057,468.16 |
| 210203 | ҮОМШ өвчний даатгал | 4,283,373.09 | 4,022,454.46 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,036,853.25 | 954,013.63 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 10,368,511.26 | 9,540,134.60 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **39,244,599.00** | **38,270,534.00** |
| 210301 | Гэрэл цахилгаан | 3,346,211.00 | 2,911,261.00 |
| 210302 | Түлш, халаалт | 2,501,809.00 | 2,488,673.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 44,179.00 | 1,016,200.00 |
| 210304 | Байрны түрээс | 33,352,400.00 | 31,854,400.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **45,476,133.00** | **55,474,966.33** |
| 210401 | Бичиг хэрэг | 7,526,394.00 | 12,261,202.93 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 23,318,300.00 | 20,554,100.00 |
| 210403 | Шуудан холбоо, интернэтийн төлбөр | 7,737,969.00 | 7,134,136.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 250,000.00 | 250,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 6,643,470.00 | 3,775,600.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | - | 15,633.28 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | - | 11,484,294.12 |

| | | | |
|---|---|---|---|
| **2105** | **Нормативт зардал** | **13,737,000.00** | **17,482,970.00** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 10,162,000.00 | 14,562,170.00 |
| 210502 | Хоол, Хүнс | 1,800,000.00 | 2,920,800.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,775,000.00 | - |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **48,793,324.00** | **45,168,111.00** |
| 210601 | Багаж, техник хэрэгсэл | | 15,000,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл | 37,143,354.00 | 23,475,381.00 |
| 210604 | Урсгал засвар | 11,649,970.00 | 6,692,730.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **9,707,200.00** | **17,703,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 9,707,200.00 | 17,703,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **14,283,180.00** | **7,540,172.50** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 10,502,000.00 | 2,697,300.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,164,500.00 | 70,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 294,000.00 | 232,020.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 295,396.00 | 237,856.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 110,000.00 | 110,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 311,000.00 | 1,702,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 450,000.00 | 225,000.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 1,156,284.00 | 2,265,996.50 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **103,942,984.11** | **46,940,816.46** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 252,000.00 | 7,882,500.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,003,690.00 | 1,500,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдлын зардал | 102,687,294.11 | 37,558,316.46 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **117,820,222.14** | **53,164,757.68** |
| **2131** | **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | **115,550,038.14** | **50,264,757.68** |
| 213101 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | 59,001,438.14 | 21,480,107.68 |
| 213102 | Засгийн газрын гадаад шилжүүлэг | 56,548,600.00 | 28,784,650.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **2,270,184.00** | **2,900,000.00** |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | - | - |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,270,184.00 | 2,900,000.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **(72,874,296.61)** | **(54,679,817.65)** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | - | 547,965.10 |
| **225001** | Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз | - | 547,965.10 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН** | - | (547,965.10) |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | (72,874,296.61) | (55,227,782.75) |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | **885,160,900.00** | **773,476,350.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | 56,710,500.00 | 28,784,650.00 |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **56,710,500.00** | **28,784,650.00** |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 56,710,500.00 | 28,784,650.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 56,710,500.00 | 28,784,650.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **828,450,400.00** | **744,691,700.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **827,698,400.00** | **724,691,700.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 827,698,400.00 | 724,691,700.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **752,000.00** | **20,000,000.00** |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 20,000,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 752,000.00 | - |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | 873,535,700.00 | 769,274,350.00 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 873,535,700.00 | 769,274,350.00 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 755,715,477.86 | 716,109,592.32 |
| **2101** | **Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил** | **536,066,722.95** | **506,962,115.22** |
| 210101 | Үндсэн цалин | 383,329,957.85 | 394,984,850.87 |
| 210102 | Нэмэгдэл | 140,523,765.10 | 84,844,032.17 |
| 210103 | Унаа хоолны Хөнгөлөлт | 12,213,000.00 | 11,438,610.05 |
| 210104 | Урамшуулал | | 15,694,622.13 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **69,686,180.91** | **63,561,791.10** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 48,584,426.92 | 43,987,720.25 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,413,016.39 | 5,057,468.16 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,283,373.09 | 4,022,454.46 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,036,853.25 | 954,013.63 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 10,368,511.26 | 9,540,134.60 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **39,244,599.00** | **38,270,534.00** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,346,211.00 | 2,911,261.00 |
| 210302 | Түлш, халаалт | 2,501,809.00 | 2,488,673.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 44,179.00 | 1,016,200.00 |
| 210304 | Байрны түрээс | 33,352,400.00 | 31,854,400.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **43,102,069.00** | **33,686,336.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 10,115,700.00 | 6,467,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 19,879,100.00 | 16,591,600.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 7,737,969.00 | 7,090,136.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 250,000.00 | 250,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 5,119,300.00 | 3,287,600.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **16,215,000.00** | **13,304,910.00** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 12,640,000.00 | 10,495,110.00 |
| 210502 | Хоол, хүнс | 1,800,000.00 | 2,809,800.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,775,000.00 | - |

| | | | |
|---|---|---|---|
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **25,939,120.00** | **26,752,730.00** |
| 210601 | Багаж, техник хэрэгсэл | | 15,000,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 14,289,150.00 | 5,060,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 11,649,970.00 | 6,692,730.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **9,707,200.00** | **17,703,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 9,707,200.00 | 17,703,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **14,498,896.00** | **5,868,176.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 10,502,000.00 | 2,741,300.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,164,500.00 | 70,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 294,000.00 | 232,020.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 295,396.00 | 237,856.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 110,000.00 | 110,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 311,000.00 | 1,702,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 450,000.00 | 225,000.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 1,372,000.00 | 550,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **1,255,690.00** | **10,000,000.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 252,000.00 | 8,500,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,003,690.00 | 1,500,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **117,820,222.14** | **53,164,757.68** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **2,270,184.00** | **2,900,000.00** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,270,184.00 | 2,900,000.00 |
| **2133** | **УЛСЫН ТӨСВӨӨС ОЛГОСОН САНХҮҮЖИЛТ, ШИЛЖҮҮЛЭГ** | **115,550,038.14** | **50,261,757.68** |
| 213301 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 59,001,438.14 | 21,480,107.68 |
| 213306 | Улсын төсөвт орлого төвлөрүүлэх шилжүүлэг | 56,548,600.00 | 28,784,650.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **2,270,184.00** | **2,900,000.00** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,270,184.00 | 2,900,000.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **11,625,200.00** | **4,202,000.00** |
| | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | - | - |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **11,625,200.00** | **4,202,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **11,625,200.00** | **4,202,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | **11,625,200.00** | **4,202,000.00** |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 11,625,200.00 | 4,202,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(11,625,200.00)** | **(4,202,000.00)** |
| | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН** | - | - |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)** | - | - |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | - | - |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | - |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/Төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | 2021 оны 01-р сарын 01-ээрх үлдэгдэл | 352,787,782.82 | 590,683.14 | 23,434,453.95 | 376,812,919.91 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| C03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 352,787,782.82 | 590,683.14 | 23,434,453.95 | 376,812,919.91 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | - | - | - | - |
| C05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | - | - | - | - |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - |
| C07 | Тайлант үеийн үр дүн | - | - | (72,874,296.61) | (72,874,296.61) |
| C08 | 2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | 352,787,782.82 | 590,683.14 | (49,439,842.66) | 303,938,623.30 |
| D01 | 2022 оны 01-р сарын 01-ээрх үлдэгдэл | 352,787,782.82 | 590,683.14 | (49,439,842.66) | 303,938,623.30 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 352,787,782.82 | 590,683.14 | (49,439,842.66) | 303,938,623.30 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | - | - | - | - |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | - | - | - | - |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | - | - | - | - |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | (55,227,782.75) | (55,227,782.75) |
| D09 | 2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | 352,787,782.82 | 590,683.14 | (104,667,625.41) | 248,710,840.55 |

XTO5430@9022899

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | хувь |
|---|---|---|---|---|---|
| 2 | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **724,691,700.00** | **703,211,592.32** | **21,480,107.68-** | **97.0** |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **724,691,700.00** | **703,211,592.32** | **21,480,107.68-** | **97.0** |
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **721,682,100.00** | **700,311,592.32** | **(21,370,507.68)** | **97.0** |
| 2101 | **Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил** | **521,162,800.00** | **506,962,115.22** | **(14,200,684.78)** | **97.3** |
| 210101 | Үндсэн цалин | 364,105,700.00 | 394,984,850.87 | **30,879,150.87** | 108.5 |
| 210102 | Нэмэгдэл | 113,105,100.00 | 84,844,032.17 | **(28,261,067.83)** | 75.0 |
| 210103 | Унаа хоолны Хөнгөлөлт | 16,492,000.00 | 11,438,610.05 | **(5,053,389.95)** | 69.4 |
| 210104 | Урамшуулал | 27,460,000.00 | 15,694,622.13 | **(11,765,377.87)** | |
| 2102 | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **67,948,900.00** | **63,561,791.10** | **(4,387,108.90)** | **93.5** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 46,205,300.00 | 43,987,720.25 | (2,217,579.75) | 95.2 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,435,900.00 | 5,057,468.16 | (378,431.84) | 93.0 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,348,700.00 | 4,022,454.46 | (326,245.54) | 92.5 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,087,200.00 | 954,013.63 | (133,186.37) | 87.7 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 10,871,800.00 | 9,540,134.60 | (1,331,665.40) | 87.8 |
| 2103 | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **40,485,400.00** | **38,270,534.00** | **(2,214,866.00)** | **94.5** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,985,800.00 | 2,911,261.00 | (1,074,539.00) | 73.0 |
| 210302 | Түлш, халаалт | 3,629,000.00 | 2,488,673.00 | (1,140,327.00) | 68.6 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,016,200.00 | 1,016,200.00 | - | 100.0 |
| 210304 | Байрны түрээс | 31,854,400.00 | 31,854,400.00 | - | 100.0 |
| 2104 | **Хангамж, бараа материалын зардал** | **34,040,400.00** | **33,686,336.00** | **(354,064.00)** | **99.0** |
| 210401 | Бичиг хэрэг | 6,467,000.00 | 6,467,000.00 | **-** | 100.0 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 16,591,600.00 | 16,591,600.00 | - | 100.0 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 7,444,200.00 | 7,090,136.00 | (354,064.00) | 95.2 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 250,000.00 | 250,000.00 | - | 100.0 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,287,600.00 | 3,287,600.00 | - | 100.0 |
| 2105 | **Нормативт зардал** | **13,331,300.00** | **13,304,910.00** | **(26,390.00)** | **99.8** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 10,521,400.00 | 10,495,110.00 | (26,290.00) | 99.8 |
| 210502 | Хоол, хүнс | 2,809,900.00 | 2,809,800.00 | (100.00) | 100.0 |
| 2106 | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **15,955,000.00** | **15,954,730.00** | **(270.00)** | **100.0** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 4,202,100.00 | 4,202,000.00 | (100.00) | 100.0 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 5,060,000.00 | 5,060,000.00 | - | 100.0 |

XTO5430 ⊕ 9022899

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210604 | Урсгал засвар | 6,692,900.00 | 6,692,730.00 | (170.00) | 100.0 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **17,703,000.00** | **17,703,000.00** | **-** | **100.0** |
| 210702 | Дотоод албан томилолт | 17,703,000.00 | 17,703,000.00 | - | 100.0 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **6,055,300.00** | **5,868,176.00** | **(187,124.00)** | **96.9** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,741,300.00 | 2,741,300.00 | - | 100.0 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 70,000.00 | 70,000.00 | - | 100.0 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 294,000.00 | 232,020.00 | (61,980.00) | 78.9 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 363,000.00 | 237,856.00 | (125,144.00) | 65.5 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 110,000.00 | 110,000.00 | - | 100.0 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,702,000.00 | 1,702,000.00 | - | 100.0 |
| 210807 | Газрын төлбөр | 225,000.00 | 225,000.00 | - | 100.0 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 550,000.00 | 550,000.00 | - | 100.0 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **5,000,000.00** | **5,000,000.00** | **-** | **100.0** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 3,500,000.00 | 3,500,000.00 | - | 100.0 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага | 1,500,000.00 | 1,500,000.00 | - | 100.0 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **3,009,600.00** | **2,900,00.00** | **(109,600.00)** | **96.4** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **3,009,600.00** | **2,900,000.00** | **(109,600.00)** | **96.4** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 3,009,600.00 | 2,900,000.00 | (109,600.00) | 96.4 |
| 1310 | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **724,691,700.00** | 703,211,592.32 | **21,480,107.68-** | **97.0** |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 724,691,700.00 | 703,211,592.32 | 21,480,107.68 | 97.0 |
| 4 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | - | - | **-** | **-** |
| 5 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | - | **-** | **-** |
| **6** | **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | 42 | 35 | (7) | 83.33 |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 1 | 1 | - | 100.0 |
| 610001 | Төсвийн байгууллага | 1 | 1 | - | 100.0 |
| **62** | **АЖИЛЛАГСДЫН ТОО** | 42 | 35 | (7) | 83.33 |
| 620001 | Удирдах ажилтан | 1 | 1 | - | 100.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 33 | 26 | (7) | 78.79 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 8 | 8 | - | 100.00 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **752,000.00** | **20,000,000.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **752,000.00** | **20,000,000.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **752,000.00** | **20,000,000.00** |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **500,000.00** | **-** |
| 210401 | Бичиг хэрэг | - | - |
| 210402 | Тээвэр, шатахуун | 500,000.00 | - |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **-** | **15,000,000.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | - | 15,000,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **252,000.00** | **5,000,000.00** |
| **210901** | Бараа үйлчилгээний бусад зардал | 252,000.00 | 5,000,000.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **752,000.00** | **20,000,000.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **752,000.00** | **20,000,000.00** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 752,000.00 | 20,000,000.00 |
| IV | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | **-** | **-** |
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **-** | **-** |
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **-** | **-** |

ХТО5430@9022690

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Мэргэжлийн хяналтын газар нь тайлант онд 1 хөтөлбөр, 4 арга хэмжээг төлөвлөн аймгийн нутаг дэвсгэрт хуулийг сахиулан, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, чанартай бүтээгдэхүүн үйлчилгээ хэрэглэх, хүний болон нийгмийн тогтвортой хөгжил, бизнес эрхлэх таатай орчин нөхцөлийг бүрдүүлэх, бүтээгдэхүүний ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагыг хангахад хяналт тавих үйлчилгээг үзүүлж байна

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах, чанартай бүтээгдэхүүн, үйлчилгээ хэрэглэх, бизнес эрхлэх таатай орчныг бий болгоход үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн төрийн захиргааны мэргэжлийн хяналтыг олон улсын жишигт нийцүүлэн хэрэгжүүлэх, эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг зөвлөн туслах үйлчилгээ, сургалт, тандалт судалгаа, хяналт шинжилгээний арга хэлбэртэй хослуулах, эрсдэлийн судалгаа, баазыг өргөжүүлэх замаар эрсдэлийн удирдлагын тогтолцоог төлөвшүүлэх, сайжруулах зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн ажилласан байна.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь Төрийн албаны тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Төсвийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоол "Босго үнэ шинэчлэн батлах", Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоол, "Журам батлах тухай" 2019 оны 472 дугаар тогтоол "Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай", 2022 оны 192 дугаар тогтоол "Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай", Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын санхүүгийн тайлан бэлтгэх заавар" зэргийг үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- *Төрийн хэмнэлтийн тухай хууль*
- *Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга*

Төсвийн шууд захирагч зарлагын гүйлгээнд гарын үсэг зурснаар дотоод хяналтыг хэрэгжүүлж байгаа бол аймгийн төрийн сан холбогдох санхүүгийн баримт материал, гүйцэтгэлийн баримт бичгийг хянаж, зарлагын гүйлгээг хийж байна.

Иймд төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг үр нөлөөтэй гэж тодорхойлон, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэх шаардлагагүй гэж үзсэн.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Мэргэжлийн хяналтын газрын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримталын дагуу бэлтгэсэн байна.

**3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Дархан-Уул аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 55,227.8 мянган төгрөгөөр буюу 18.2 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгө зэрэг данс байна

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | - | - | - |
| Авлага | - | - | - |
| Бараа материал | 105,252.5 | 59,252.2 | (46,000.3) |
| Үндсэн хөрөнгө | 198,686.1 | 189,458.6 | (9,227.5) |
| **Нийт хөрөнгө** | **303,938.6** | **248,710.8** | **(55,227.8)** |
| Өр төлбөр | - | - | - |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 303,938.6 | 248,710.8 | (55,227.8) |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | 303,938.6 | 248,710.8 | (55,227.8) |

Бараа материал дансны үлдэгдэл 46,000.3 мянган төгрөгөөр буурсан нь МХЕГ-аас 1,373.7 мянган төгрөгийн бараа материал, "Сод Монгол" ХХК-аас гэрээнд заасны дагуу 150.0 мянган төгрөгийн шатахууны урамшууллыг орлогод авч, ТӨБЗГ-ын 2022 оны 12 сарын 30-ны өдрийн А/2670 тоот албан бичгийн дагуу 2,087.5 мянган төгрөгийн бараа материалыг эргэлтийн хөрөнгөөс үндсэн хөрөнгийн дансанд шилжүүлж, газрын даргын 2022 оны 09 сарын 30-ны өдрийн А/19, 2022 оны 12 сарын 30-ны өдрийн А/30 тоот тушаалын дагуу 11,380.8 мянган төгрөгийн эргэлтийн хөрөнгийг акталсан, 84,188.1 мянган төгрөгийг зарцуулсан зэргээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгийн дансны хувьд МХЕГ-ын 2022 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн А/21 дүгээр тушаалаар үнэ төлбөргүйгээр 21,925.3 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг хүлээн авч, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны 03 сарын 17-ны өдрийн 90 дүгээр тогтоолын дагуу 5,836.8 мянган төгрөгийн балансын үнэтэй хөрөнгийг аймгийн Гаалийн газарт шилжүүлж, 32,269.4 мянган төгрөгийн элэгдэл байгуулсантай холбоотойгоор буурсан байна.

Байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 128,293.8 мянган төгрөгөөр буюу 13.8 хувиар буурсан нь Засгийн газрын 2022 оны 417 дугаар тогтоолын дагуу Мэргэжлийн хяналтын газар татан буугдаж байгаатай холбоотойгоор экспорт импорт хилийн хорио цээрийн хяналтын чиг үүрэг гаалийн байгууллагад шилжиж, шинжилгээний дээжийн тоо буурснаас шалтгаалжээ.

Нийт зардал өмнөх оноос 146,488,3 мянган төгрөг буюу 14,6 хувиар буурсан байна. Өмнөх оны өөрчлөлтөөс материаллаг өөрчлөлт гарсан цалин хөлс нэмэгдэл урамшуулал 29,104.6 мянга, ажил олгогчоос нийгмийн даатгал төлөх шимтгэл 6,124.4 мянга, байр

ашиглалттай холбоотой тогтмол зардал 974.1 мянга, эд хогшил худалдан авах зардал 3,625.2 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж 6,743.0 мянга, бараа үйлчилгээний бусад зардал 57,002.1 мянган төгрөгөөр тус тус буурсан байна.

Эдгээр зардлын бууралт нь хяналт шалгалтын зарим чиг үүрэг бусад байгууллагад шилжсэнээр 6 орон тоо хасагдаж, батлагдсан орон тооноос 7 сул орон тоо нөхөөгүй, элэгдлийн зардлын бууралт зэргээс шалтгаалсан байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүнг хаасан нягтлан бодох бүртгэлийн залруулга байхгүй.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,039,610.0 мянган төгрөгийг тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 314,918.3 мянган төгрөгөөр бууруулж, 724,691.7 мянган төгрөгөөр баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 724,691.7 мянган төгрөгийг улсын төсвөөс бүрдүүлсэн байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 724,691.7 мянган төгрөгийн санхүүжилт авч, улсын төсөвт 28,784.6 мянган төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 703,211.5 мянган төгрөг буюу 97.4 хувьтай байгаа нь 7 орон тоо дутуу ажилласнаас цалин хөлсийг 14,200.7 мянга, ажил олгогчоос төлөх НДШ-ийг 4,387.1 мянга, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 2,214.8 мянга, хангамж бараа материалыг 354.1 мянга, нормативт зардлыг 26.7 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийг 187.1 мянга, нэг удаагийн тэтгэмж урамшууллыг 109.6 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | **70417- Мэргэжлийн хяналт** | **724,691.7** | **703,211.6** | **21,480.1** | **97.4** |
| 1.1 | 80101-Үндсэн үйл ажиллагааны зардал | 720,940.8 | 699,570.3 | 21,370.5 | 97.4 |
| 1.2 | 80205- Мэдээлэл, сурталчилгааны зардал | 77.3 | 77.3 | 0,0 | 100.0 |
| 1.3 | 80227- Лабораторийн итгэмжлэл | 664.0 | 664.0 | 0,0 | 100.0 |
| 1.4 | 80802- Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал, дэмжлэг | 3,009.6 | 2,900.0 | 109.6 | 96.3% |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус газарт аймгийн засаг даргын нөөц сангаас 2022 оны А/184 тоот захирамжаар "Үндэсний их баяр наадам"-ын худалдаа үйлдвэрлэл, үйлчилгээний хяналтын зардалд 5,000.0 мянга, А/254 тоот захирамжаар гамшгийн үед ашиглах зөөврийн ажлын байр худалдан авахад 15,000.0 мянган төгрөгийн санхүүжилтийг олгож, зориулалтын дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Мэргэжлийн хяналтын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Дархан-уул аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Х.Сувдмаа гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор С.Батцэцэг, аудитын менежер У.Батсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Мэргэжлийн хяналтын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ний өдрийн 01 тоот албан бичгээр 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны батлагдсан төсвийн 724,691.7 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 10,870.4 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор МХЕГ-аас хуулийг мөрдөж ажиллах чиглэл ирүүлсэн байна.

Хуулийн хүрээнд батлагдсан төсвийг нийт 21,480.1 мянган төгрөг хэмнэж, төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн шууд захирагч Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж ажилласан байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээлбэл зохих 168 мэдээллийг хуульд заасан хугацаанд бүрэн байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгээгүй болно.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар нийт 1,088.6 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрч, 1,088.6 мянган төгрөгийн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлж ажилласан байна.

*Хүснэгт 4. Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Зөвлөмж | 1 | 1,088.6 | 1 | 1,088.6 | 100.0 |
| **Нийт дүн** | **1** | **1,088.6** | **1** | **1,088.6** | **100.0** |

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудал байхгүй болно.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар төлбөрийн акт тогтоох, албан шаардлага, зөвлөмж өгөх зөрчилтэй асуудал илрээгүй болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.